



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

┌ Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 23.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Сөдөт” ХК-ийн оноосон нэрийг “Азиапасифик пропертис” ХК болгон өөрчлөн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар/С.Тулгаа/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Азиапасифик пропертис” ХК/Лий Майкл Кашелл/-д үүрэг болгосугай.

3. Энэ тухай Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдэгдэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН